

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ АСУУДЛААРХИ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 22 дугаар зүйлийн 22.4, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг баримтлан Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшиүүлэх тухай асуудлыг Байнгын хороо 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Данзангийн Лүндээжанцанг нэр дэвшиүүлэх тухай Улсын Их Хурлын дарга М.Энхболдоос гаргасан саналыг хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нь 1990 оноос хойш Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын гишүүнээр 8 дахь удаагаа сонгогдон ажиллаж байна. Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллах хугацаандаа Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар тус тус сонгогдон ажиллаж байсан.

Байнгын хорооны даргад нэр дэвшиүүлэх тухай асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан төрийн байгууллагын түвшинд авлига, хүнд суртлыг арилгах, төрийн албаны хариуцлагыг сайжруулах, Төрийн албаны зөвлөлийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх асуудлыг бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх, Улсын Их Хурлаас батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад идэвх, санаачилгатай ажиллах, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч, улс төрийн намууд, эрдэмтэн, судлаач, иргэдийн оролцоотойгоор зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэж ажиллах талаар саналаа хэлсэн болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Данзангийн Лүндээжанцанг нэр дэвшиүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшиүүлэх асуудлаархи Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ**

Д.ТОГТОХСҮРЭН

